Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

✓	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлагдсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Прокурорын байгууллагын үйл ажиллагааны зорилго, хэтийн төлөв, бодлого, чиглэлийг тодорхойлсон Улсын ерөнхий прокурорын шийдвэр, эрх зүйн бусад баримт бичгийг нэгтгэн боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хууль тогтоомж болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, эрх зүйн баримт бичгийн хууль зүйн үндэслэлийг хянах, байгууллагын хууль ёсны эрх ашиг сонирхлыг төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэх.

Албан тушаалын зорилт:
1.Прокурорын байгууллагын үйл ажиллагааны зорилго, хэтийн төлөв, бодлого, чиглэлийг тодорхойлсон Улсын ерөнхий прокурорын шийдвэр, эрх зүйн бусад баримт бичгийг нэгтгэн боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
2.Хууль тогтоомж болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг удирдан зохион байгуулах;
3.Эрх зүйн баримт бичгийн төслийн хууль зүйн үндэслэлийг хянах, хууль тогтоомжийг системчлэх, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг судлан шийдвэрлүүлэх, холбогдох хууль тогтоомжийн төсөлд санал өгөх ажлыг нэгтгэн зохион байгуулах, байгууллагын хууль ёсны эрх ашиг сонирхлыг төлөөлөх;
4.Прокурор, ажилтны үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Прокурорын байгууллагын бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох.	Хуульд нийцсэн, бодитой хэрэгжихүйц байна.	Г, Х
	1.2.Газрын чиг үүрэгт хамаарах ажлын чиглэлээр байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөгдөх эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах.	Хуульд нийцсэн, бодитой хэрэгжихүйц, шаардлага хангасан байна.	Г, Х
	1.3.Улсын ерөнхий прокуророос хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хуралд хийх мэдээлэл, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүхтэй харилцах асуудлаар гаргах санал, дүгнэлт, тайлбарын төслийг нэгтгэн боловсруулах.	Үндэслэл бүхий мэдээлэл, санал, дүгнэлт, тайлбар боловсруулсан байна.	Г, Х
	1.4.Прокурорын байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг нэгтгэн боловсруулж батлуулах, ~~түүний~~ биелэлтэд хяналт тавих.	Төлөвлөлтөд тавигдах шаардлага нийцсэн, биелэлт, үр дүнг бодитой тооцсон байна.	Г, Х
	1.5.Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулах, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг	Аргачилсан зааварт заасан шаардлагын дагуу зохион байгуулалтыг хангаж, шийдвэр нь биелэгдсэн байна.	Х

	хангуулах, биелэлтэд хяналт тавих.		
	1.6.Нэгж прокурорын газрын ажлыг иж бүрэн болон хэсэгчлэн шалган туслах, танилцах ажлыг нэгтгэн зохион байгуулах.	Зохион байгуулалтыг хангасан байна.	Х
	1.7.Прокурорын байгууллагын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн, тайлан хамгаалалтыг зохион байгуулах.	Зохион байгуулалтыг хангасан байна.	Х
	1.8.Прокурорын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох байгууллагад ~~нэгтгэн~~ тайлагнах.	Биелэлт, үр дүнг бодитой тооцож, тайлагнасан байна.	Х
	1.9.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар прокурорын байгууллагаас хүргүүлж буй тайлан, мэдээ, мэдээллийг боловсруулах.	Холбогдох мэдээллийг үндэслэл бүхий боловсруулсан байна.	Г, Х
	1.10.Олон улсын гэрээ, олон улсын байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлангийн хуралд оролцох, Засгийн газраас баталсан Ажлын хэсэгт прокурорын байгууллагыг төлөөлөх.	Прокурорын байгууллагын төлөөллийг хэрэгжүүлсэн байна.	Г
	1.11.Нэгж прокурорын газарт хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих.	Үндэслэл бүхий үүрэг даалгавар өгч, үр дүнг тооцсон байна.	Х, Ш
	1.12.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос өгсөн үүргийг хэрэгжүүлж, хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр хангах.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, мэдээллээр хангасан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг удирдан зохион байгуулах.	Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой хийсэн байна.	Х, Ш
	2.2.Прокурорын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг удирдан зохион байгуулах.	Байгууллагын үйл ажиллагаанд бодитой үнэлэлт дүгнэлт өгсөн байна.	Х, Ш
	2.3.Прокурорын байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээг боловсронгуй болгох	Хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, мэдээ боловсронгуй болсон байна.	Г, Х

	хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, шийдвэрлүүлэх.		
	2.4.Прокурорын байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээг нэгтгэн, Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Үндэсний статистикийн хороонд мэдээ хугацаандаа хүргэгдсэн байна.	Х
	2.5.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журамд заасан мэдээ, танилцуулгыг нэгтгэн дүгнэж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	Х
	2.6.Прокурорын байгууллагын хагас, бүтэн жилийн мэдээ, тайланг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох.	Мэдээ, тайлан нэгтгэгдэж, цаашид авах арга хэмжээ тодорхойлогдсон байна.	Г, Х
	2.7.Прокурорын байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээллийг төрийн нээлттэй өгөгдлийн системд нийтлүүлэх ажлыг зохион байгуулах.	Иргэдийг мэдээллээр хангасан байна.	Х
	2.8. Хууль, заавар, журмын хэрэгжилт, шалгалт, судалгааны дүнгийн талаар нэгж прокурорын газар зөвлөмж, мэдээлэл, албан бичиг хүргүүлж, үр дүнг тооцох.	Үр дүнг тооцсон байна.	Г, Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Хууль санаачлагч болон бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журам, зааврын төсөл, мэдээлэл, албан бичигт санал, хариу өгөх, тайлбар гаргах, баримт бичиг, бусад мэдээллийг хүргүүлэх ажлыг нэгтгэн зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Х, Ш
	3.2.Захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, гэрээний төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж зөвлөмж өгөх.	Зөвлөмж нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Х, Ш
	3.3.Прокурорын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын ерөнхий прокурорын тушаал, эрх зүйн баримт бичгийг системчлэн кодификац хийх, нэгдсэн сан бүрдүүлэх.	Эрх зүйн баримт бичиг системчлэгдэж, нэгдсэн сан бүрдсэн байна.	Х
	3.4.Захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн	Бүртгэгдвэл зохих захиргааны хэм хэмжээний акт	Г, Х

	захиргааны төв байгууллагад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах.	бүртгэгдсэн байна.	
	3.5.Хууль тогтоомжид Улсын ерөнхий прокурор, прокурорын байгууллага бусад байгууллага, эрх бүхий албан тушаалтантай хамтран батлахаар зохицуулсан дүрэм, журам, зааврын судалгаа, бүртгэл хөтөлж, хэрэгжилтэд хяналт тавих.	Бүртгэл хөтлөгдөж, тогтмол баяжилт хийгдсэн байна.	Х
	3.6.Улсын ерөнхий прокурор дангаараа болон бусад байгууллагатай хамтран баталсан дүрэм, журам, эрх зүйн баримт бичигт давхардал, эрх зүйн хийдэл байгаа эсэхийг судалж, зөрчлийг арилгах арга хэмжээ авах.	Судалгаа хийгдэж, зөрчил арилсан байна.	Х
	3.7.Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох шаардлагыг судлан, санал, төсөл боловсруулах асуудлыг нэгтгэн зохион байгуулах.	Зохион байгуулалтыг хангасан байна.	Х
	3.8.Прокурорын байгууллагаас хууль, заавар, журам болон бусад баримт бичигт хүргүүлсэн саналын судалгааг хөтөлж, хяналт-шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах.	Судалгаа хөтлөгдөж, хяналт-шинжилгээ хийгдсэн байна.	Х
	3.9.Прокурорын байгууллагын хууль ёсны эрх ашгийг итгэмжлэлийн үндсэн дээр хууль сахиулах байгууллага болон шүүхэд төлөөлөн оролцох.	Байгууллагын хууль ёсны эрх ашиг хангагдсан байна.	Х
	3.10.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах, хэлэлцүүлэг, бусад арга хэмжээнд оролцох.	Байгууллага төлөөлж үйл ажиллагаанд үр дүнтэй оролцоно.	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Газрын прокуроруудын ажил үүргийг оновчтой хуваарилж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.	Ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна.	Х
	4.2.Газрын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг тооцох.	Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулсан байна.	Г, Х, Ш
	4.3.Газраас хийж гүйцэтгэсэн ажлын мэдээ, тайланг гаргуулж, дүн шинжилгээ хийх, хяналтын ажлыг сайжруулахад чиглэсэн ажил, арга хэмжээг оновчтой тодорхойлж, хэрэгжилтийг хангах.	Мэдээ, тайланд үндэслэн үр дүнтэй ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн, биелэлтийг тооцсон байна.	Х, Ш

	4.4.Газрын хэмжээнд хяналтын ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлүүлэн, хяналт тавих.	Газрын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн хэрэгжүүлсэн байна.	Х
	4.5.Хариуцсан хяналтын чиглэлээр Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд асуудал хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх.	Шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г, Х
	4.6.Газрын чиг үүрэгт хамаарах аливаа асуудлаар зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, хариуцсан ажлын бодлого, зорилтыг уялдуулах.	Ажлын уялдаа холбоог хангасан байна.	Г, Х, Ш
	4.7.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х
	4.8.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эрх зүй (0421)	
Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Дээд шатны прокуророор 3-аас доошгүй жил, эсхүл Улсын ерөнхий прокурорын газарт ахлах прокуророор ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-газрын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдэлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдэлийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны эерэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах;

		-хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах; -албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
1.Улсын ерөнхий прокурор
2.Улсын ерөнхий прокурорын орлогч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
1.Газрын ахлах прокурор 2.Газрын хяналтын прокурор 3.Газрын туслах ажилтан 4.Аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор 5.Аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч 6.Нийслэлийн прокурорын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, хяналтын прокурор Нийт: 6	1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2.Төрийн байгууллага 3.Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр
Дугаар: А/95

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
ТӨРИЙН ХУУЛЬ ЦАА8ЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН

2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр